

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Хөшөөт хөгжил сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/39/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: А.Нарандэлгэр

Утас: 70432545

цахим хаяг: narandelgera@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3. Аудитын тайлан	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	12
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
4.1 Залруулсан алдаа.....	13
4.2 Төлбөрийн акт.....	14
4.3 Албан шаардлага	14
4.4 Зөвлөмж	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	15

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ХОА	Ховд аймаг
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ШША	Шүүх шинжилгээний алба
БОЭТ	Бүсийн оношилгоо эмчилгээний төв



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ХӨШӨӨТ ХӨГЖИЛ
САНГИЙН ЗАХИРАЛ
Т.МЯГМАРДОРЖ ТАНАА

2022.03.15 № 02/110

танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Хөшөөт хөгжил сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тайлант оны авлагыг дутуу тайлагнасан, хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудыг данс бүртгэлд тусгаагүй, ашиглагч байгууллагууд нь үйл ажиллагаандаа ашиглахгүй байгаа, өмнөх оны өглөг авлагыг барагдуулж ажиллаагүй, санхүүгийн тайлан тушаах хугацааг баримтлаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, 16.5.4-д "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 8.9.1-д "Төсвийн шууд захирагчсанхүүгийн тайланг дараа оны 01 сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 сарын 25-ны дотор харьяалах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.3-д "Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана" Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4.30-д "Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө, хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай үнэлэх боломжтой" гэсэн заалтуудтай тус тус нийцээгүй, "Үнэн зөв байх", "Иж бүрэн байх", "Тохиолдсон байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>121,449,731.78</u>	<u>662,408,722.45</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,636,393.88	30,013,233.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	7,636,393.88	30,013,233.55
3121	Төгрөг	7,636,393.88	30,013,233.55
31211	Төрийн сангийн харилцах	7,636,393.88	30,013,233.55
33	АВЛАГА	109,668,287.90	627,350,938.90
33300	Татаас, санхүүжилтийн авлага	68,568,287.90	601,250,938.90
335	Бусад авлага	41,100,000.00	26,100,000.00
3351	Байгууллагаас авах авлага	41,100,000.00	26,100,000.00
34	УРЬДЧИЛГАА	1,231,700.00	1,733,900.00
34600	Урьдчилж гарсан зардал	1,231,700.00	1,733,900.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,913,350.00	3,310,650.00
354	Хангамжийн материал	2,913,350.00	3,310,650.00
35410	Бичиг хэргийн материал	637,750.00	969,050.00
35420	Аж ахуйн материал	2,275,600.00	2,341,600.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>6,924,433.05</u>	<u>5,207,219.70</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,924,433.05	5,207,219.70
392	Биет хөрөнгө	6,143,183.11	4,738,469.80
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,979,800.00	9,979,800.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,816,200.04)	(7,336,149.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	3,950,000.00	4,499,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(1,970,416.85)	(2,405,080.28)
393	Биет бус хөрөнгө	781,249.94	468,749.90
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(468,750.06)	(781,250.10)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>128,374,164.83</u>	<u>667,615,942.15</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>10,570,902.43</u>	<u>543,308,350.81</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,570,902.43	543,308,350.81
413	Өглөг	10,570,902.43	543,308,350.81
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,215,059.04	2,209,317.42
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,100.00	4,100.00
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг	-	204,714,874.00
4136	Бусад өглөг	8,351,743.39	336,380,059.39
41361	Байгууллагад төлөх өглөг	7,711,733.39	335,740,049.39
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	640,010.00	640,010.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>117,803,262.40</u>	<u>124,307,591.34</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	117,803,262.40	124,307,591.34
512	Хуримтлагдсан үр дүн	117,803,262.40	124,307,591.34
51210	Өмнөх үеийн үр дүн	117,803,262.40	117,803,262.40
51220	Тайлант үеийн үр дүн	-	6,504,328.94
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>128,374,164.83</u>	<u>667,615,942.15</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,579,251,489.23	1,706,033,977.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,579,251,489.23	1,706,033,977.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,579,251,489.23	1,706,033,977.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,579,251,489.23	1,706,033,977.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,254,146,996.00	1,706,033,977.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	325,104,493.23	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,637,756,536.58	1,699,529,648.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	59,119,506.38	52,368,687.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	51,869,506.38	45,868,687.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,609,166.00	29,559,870.00
210101	Үндсэн цалин	26,914,523.00	29,559,870.00
210102	Нэмэгдэл	2,390,643.00	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,304,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,036,145.58	3,378,303.71
210201	Тэтгэврийн даатгал	2,744,579.16	2,197,724.68
210202	Тэтгэмжийн даатгал	322,891.66	295,144.58
210203	ҮОМШӨ-ний даатгал	258,313.13	236,115.67
210204	Ажилгүйдлийн даатгал	64,578.31	59,029.62
210205	Эрүүл мэндийн даатгал	645,783.32	590,289.16
2104	Хангамж, бараа материалын зардал	3,806,528.00	3,979,200.00
210401	Бичиг хэрэг	671,750.00	793,000.00
210402	Тээвэр, шатахуун	2,451,000.00	2,868,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	515,978.00	229,000.00
210404	Ном, хэвлэл	156,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,000.00	63,200.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	26,000.00
2107	Томилолт, зочны зардал	2,259,300.00	949,700.00
210702	Дотоод албан томилолт	1,791,000.00	718,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	468,300.00	231,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,500,000.00	5,600,000.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,000,000.00	2,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,400,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,658,366.80	2,401,613.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,185,000.00	134,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	2,473,366.80	2,267,113.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,250,000.00	6,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,250,000.00	6,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,250,000.00	6,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,578,637,030.20	1,647,160,961.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,578,637,030.20	1,647,160,961.00
220001	Барилга байгууламж	299,910,166.00	173,957,631.00
221001	Их засвар	803,944,644.20	292,847,535.00
222001	Тоног төхөөрөмж	296,849,000.00	181,091,397.00
223001	Бусад хөрөнгө	177,933,220.00	999,264,398.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(58,505,047.35)	6,504,328.94
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(58,505,047.35)	6,504,328.94

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	117,803,262.40	117,803,262.40
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	117,803,262.40	117,803,262.40
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	117,803,262.40	117,803,262.40
D08	Тайлант үеийн үр дүн			6,504,328.94	6,504,328.94
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	124,307,591.34	124,307,591.34

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,292,026,996.00	1,378,066,200.00

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,292,026,996.00	1,378,066,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,292,026,996.00	1,378,066,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,292,026,996.00	1,378,066,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,292,026,996.00	1,378,066,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	58,042,371.00	51,505,215.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	58,042,371.00	51,505,215.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	50,792,371.00	45,005,215.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	30,542,898.00	28,752,715.33
210101	Үндсэн цалин	27,040,642.00	24,076,225.33
210102	Нэмэгдэл	2,117,812.00	1,855,937.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,384,444.00	2,820,553.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,903,675.00	4,191,200.00
210201	Тэтгэврийн даатгал	1,136,039.00	2,949,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	71,568.00	310,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	57,255.00	248,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	14,313.00	62,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	624,500.00	620,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,694,798.00	3,009,500.00
210401	Бичиг хэрэг	770,000.00	770,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,818,020.00	1,818,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	749,978.00	222,000.00
210404	Ном, хэвлэл	156,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	199,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,680,000.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	200,000.00	-
210602	Тавилга	2,480,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,009,900.00	1,451,900.00
210702	Дотоод албан томилолт	1,309,900.00	1,451,900.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	700,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,261,100.00	5,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,761,100.00	2,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,400,000.00	3,000,000.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,700,000.00	1,999,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,700,000.00	1,999,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,250,000.00	6,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,250,000.00	6,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,250,000.00	6,500,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,233,984,625.00	1,326,560,984.67
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,293,403,949.20	1,304,184,145.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,293,403,949.20	1,304,184,145.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,293,403,949.20	1,304,184,145.00
220001	Барилга байгууламж	299,910,166.00	118,073,199.00
221001	Их засвар	518,711,563.20	286,345,172.00
222001	Тоног төхөөрөмж	296,849,000.00	103,629,897.00
223001	Бусад хөрөнгө	177,933,220.00	796,135,877.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,293,403,949.20)	(1,304,184,145.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(59,419,324.20)	22,376,839.67
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		7,636,393.88
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	7,636,393.88	30,013,233.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,050,200,000.00	1,355,689,360.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	54,000,000.00	51,505,215.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	47,500,000.00	45,005,215.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	31,045,300.00	28,752,715.33
210101	Үндсэн цалин	27,331,300.00	24,076,225.33
210102	Нэмэгдэл	2,277,600.00	1,855,937.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,436,400.00	2,820,553.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,191,200.00	4,191,200.00
210201	Тэтгэврийн даатгал	2,949,300.00	2,949,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	310,500.00	310,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	248,400.00	248,400.00

210204	Ажилгүйдлийн даатгал	62,100.00	62,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	620,900.00	620,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3,143,100.00	3,009,500.00
210401	Бичиг хэрэг	770,000.00	770,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,818,100.00	1,818,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	355,000.00	222,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	199,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,500,000.00	1,451,900.00
210702	Дотоод албан томилолт	1,500,000.00	1,451,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,600,000.00	5,600,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,500,000.00	2,500,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	100,000.00	100,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,020,400.00	1,999,900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,020,400.00	1,999,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,500,000.00	6,500,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	6,500,000.00	6,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,500,000.00	6,500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,996,200,000.00	1,304,184,145.00
2200	Дотоод эх үүсвэрээр	1,996,200,000.00	1,304,184,145.00
220001	Барилга байгууламж	755,200,000.00	118,073,199.00
221001	Их засвар	346,000,000.00	286,345,172.00
222001	Тоног төхөөрөмж	80,000,000.00	103,629,897.00
223001	Бусад хөрөнгө	815,000,000.00	796,135,877.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,050,200,000.00	1,378,066,200.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,050,200,000.00	1,378,066,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,050,200,000.00	1,378,066,200.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	7,636,393.88
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	30,013,233.55
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3.00	3.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	2.00	2.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Хөшөөт хөгжил сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн зарцуулалт, дотоод хяналттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор А.Нарандэлгэр 2022 оны 01 дүгээр сарын 24-нээс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаарын албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хөшөөт хөгжил сан нь Ховд аймгийн эдийн засаг нийгмийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж, нийгмийн салбарыг хөгжүүлэх байгаль орчныг хамгаалахад Аймгийн нутаг дэвсгэрт баялаг ашиглагчдын нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Тус сан нь аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийг дэмжихээр дараах салбаруудын төсөл хөтөлбөрүүдийг санхүүжүүлдэг байна. Үүнд :

1. Аймгийн болон нөлөөллийн сумдын дэд бүтцийн салбарын хөгжүүлэх.
2. Үйлдвэрлэл, үйлчилгээ, Хөдөө аж ахуйн салбарын боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих
3. Аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
4. Нийгэм соёлын салбарыг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх
5. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх
6. Аймгийн ИТХ, Засаг даргаас дэмжсэн бусад асуудлууд

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны нийт орлогын 1378.1 сая төгрөгөөс 2.0 хувиар тооцон 27.6 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 22.0 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ховд аймгийн Хөшөөт хөгжил сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 335.1 сая төгрөгөөр буюу 261.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, мөнгөн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 30.0 сая төгрөг болж 22.4 сая төгрөгөөр өссөн байна.

Тайлант оны авлага 517.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь МОЭНКО ХХК-аас авах татаас санхүүжилтийн авлага өссөнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд 15.0 сая төгрөгийн авлага буурсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3.9 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 4.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 3.1 сая төгрөгийн материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 15.2 сая төгрөг, оны эцэст 15.7 сая төгрөг болж 0.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвөөс 0.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэсэнтэй холбоотой байна.

Тайлант оны эцэст өр төлбөр дансны үлдэгдэл 543.3 сая төгрөг болж, 532.7 сая төгрөгөөр өссөн нь санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотой нөлөөллийн 2 сумдад олгох санхүүжилт, хөрөнгө оруулалтын ажлуудын үлдэгдэл санхүүжилтийг өглөгөөр тусгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 117.8 сая төгрөг байсан ба оны эцэст 124.9 сая төгрөг болж өөрчлөгдсөн нь тайлант оны үр дүнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 124.9 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймгийн Хөшөөт хөгжил сангийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2050.2 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 2,050.2 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 2,050.2 сая төгрөгийн төсөв батлагдаж, 2,050.2 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр МОЭНКО ХХК-аас хандиваар 43.5 сая төгрөг, санхүүжилтээр 1,334.5 сая төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 1,355.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт орлогын гүйцэтгэл 1,378.1 сая төгрөг буюу 67.2 хувь байгаа нь Ковид-19 цар тахалтай холбоотой нүүрсний экспортын үйл ажиллагаа зогсонги байдалд орсноор орлого тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1355.7 сая төгрөг буюу 66.1 хувьтай байгаа нь 3, 4-р улирлын санхүүжилт дутуу орж ирсэнтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын зарлагыг дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар орлого, зардлын гүйлгээ хийгдээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Тус байгууллага нь 434.3 сая төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ, 869.5 сая төгрөгийн 26 хөрөнгө оруулалтын ажлуудыг сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн байна. Тухайлбал:

- Нэгдсэн дулаанд холбогдсон сумдын албан байгууллагуудын дулааны тоолуур авах – 36.5 сая төгрөг
- БОЭТ-ийн дээврийн засвар – 35.2 сая төгрөг
- Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 48 дугаар ангийн тавиулангийн өргөтгөл барих – 75.0 сая төгрөг
- Аймгийн ЗДТГ-ын байрны ариун цэврийн өрөөний иж бүрэн засвар шинэчлэлт- 38.0
- Нутгийн удирдлагын ордны фасад засвар – 40.0 сая төгрөг
- ШША-ны Булган сумын кубоны барилга барих үлдэгдэл санхүүжилт – 70.4 сая төгрөг

- Тагнуулын газрын авто машин худалдан авах дэмжлэг – 38.0 сая төгрөг
- Төр захиргааны нэгдсэн төвийг дулаанд холбох / Жаргалант сум/ - 54.0 сая төгрөг
- Төв цэнгэлдэх хүрээлэнгийн засвар/ Жаргалант сум/ – 138.0 сая төгрөг
- Хот тохижилтын ажлын урсгал санхүүжилт – 150.0 сая төгрөг
- Иноваци технологийг нэвтрүүлэх/ Шинэ ховд/ - 50.0 сая төгрөг

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг 79.6 хувьтай мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 15.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлж ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх, анхаарал хандуулахуйц асуудал нь “Төр захиргааны нэгдсэн төвийг дулаанд холбох / Жаргалант сум” , “Нэгдсэн дулаанд холбогдсон сумдын албан байгууллагуудад дулааны тоолуур авах” ажлуудыг данс бүртгэлд тусгаж, төсвийн үр өгөөжийг дээшлүүлж ажилласан эсэхийг дахин хянаж үзэх.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 451.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 204.7 сая төгрөгийн алдааг залруулж, 1.0 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, хөрөнгийг данс бүртгэлд тусгаж, үр өгөөжийг нэмэгдүүлэх 243,8 сая төгрөгийн 2 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1,8 сая төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, 2022 оны 03 сарын 15-ны өдрийн 08 тоот албан бичгээр баталгаажуулав. Үүнд:

- Нөлөөллийн сумдын санхүүжилтийн авлага 153.4 сая төгрөг, МОЭНКО ХХК-аас авах авлага 51.3 сая төгрөгийг тус тус бүртгээгүй нийт 204.7 сая төгрөг,

4.2 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Эвийн хүч худалдааны төвийн халаалтын ажлыг гүйцэтгэсэн ГЭЭТ ХХК-аас авах зураг төсвийн авлагыг барагдуулаагүй 1.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов

4.3 Албан шаардлага

Илрүүлэлт1 : “Нэгдсэн дулаанд холбогдсон сумдын албан байгууллагуудын дулааны тоолуур авах /суурилуулах/” ажлын хүрээнд нийлүүлсэн дулааны тоолуурыг ашиглагч байгууллагууд ашиглахгүй байгаа, данс бүртгэлд тусгаагүй 39.3 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5-д “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах”, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4.30-д “Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө, хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай үнэлэх боломжтой” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Илрүүлэлт 2: Жаргалант сумын “Төр захиргааны нэгдсэн төвийг дулаанд холбох” ажлыг хүлээн авсан боловч, данс бүртгэлд тусгаагүй 204.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах”, Сангийн сайдын 388 дугаар тушаалын 4.30-д “Үндсэн хөрөнгийн зүйлийг дараах тохиолдолд хөрөнгө хэмээн хүлээн зөвшөөрнө, хөрөнгийн өртөг эсвэл бодит үнэ цэнийг найдвартай үнэлэх боломжтой” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт1: Сангийн пэйж хуудас хөтлөх, үйл ажиллагааны тайлан бэлтгэх ажлыг гүйцэтгүүлэх гэрээг хийхдээ ажлын тоо хэмжээг тодорхой тусгаагүй 1.8 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 40.3-д “Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараах нөхцөлийг заавал тусгана” гэсэн заалтыг баримталж ажиллах.

Илрүүлэлт 2: Өмнөх оны өглөг авлага барагдуулж ажиллаагүй. Тухайлбал Хүүхэд бүл гэр бүл хөгжлийн газарт хүчирхийлэлд өртсөн иргэдийг хамгаалах төвийн тохижилтын ажилд 1.9 сая төгрөг, Олзвой баатрын хөшөөний үлдэгдэл санхүүжилт 5.7 сая төгрөг, Таван эрдэнэ ХХК-д төлөх 0.6 сая төгрөгийн өр төлбөрийг барагдуулж ажиллаагүй нийт 8.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтыг баримталж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 5 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая.төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хөшөөт хөгжил сан	6	459.6	1	204.7	1	1.0	2	243.8	2	10.1

Ховд аймаг дахь Төрийн аудитын газар